



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/474

Улаанбаатар хот

**Хариуцлагатай эргүүл жижүүр
томилон ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ жилийн баярын өдрүүдэд ажиллах дүүргийн хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хариуцлагатай эргүүл, жижүүрийн үүргийг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу гүйцэтгэж хороод, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй байнга холбоо тогтоон, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж, Нийслэлийн хариуцлагатай жижүүрт 2 цаг тутам мэдээлэл өгч ажиллахыг эргүүл, жижүүрээр томилогдсон ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Баярын өдрүүдэд ажлын байрныхаа аюулгүй байдлыг хангаж, шаардлага гарвал дүүргийн хариуцлагатай жижүүрт цаг үеийн байдлыг мэдэгдэж ажиллахыг харъяа байгууллага хэлтэс, албадын дарга болон хороодын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Эргүүл жижүүрийг шаардлагатай мэдээллээр ханган, ажил үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, баярын өдрүүдэд хэрхэн ажилласан талаарх илтгэх хуудсыг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр гарган танилцуулахыг Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс /В.Батсайхан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ